

БЭЭЖИНГИЙН ЭРХ БАРИГЧДЫН АФРИКТ ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО

3. Эрдэнэчимэг

Өнөө үед Бээжингийн эрх баригчдын гадаад бодлогын стратегийн гол зорилгын нэг бол дэлхийн хувьсгалт хөдөлгөөний салшгүй хэсэг болох Ази, Африк, Латин Америкийн шинэ тулгар хөгжиж байгаа орнуудыг дэлхийн социалист хамтын нөхөрлөл, олон улсын ажилчин ангиас салган хөндийрүүлэх, Зөвлөлтийн эсрэг үзлийг дэвэргэн дэлгэрүүлэх талбар болгон ашиглах, дэлхий дахинд жанжлан ноёрхох гэсэн эрмэлзлэлээ биелүүлэх түшиц газар болгоход чиглэгдэж байна.

Хятадын удирдлага «гурав дахь ертөнцөд» жанжлан ноёрхох бодлогоо явуулах тохиромжтой газар бол Африк тив гэж үзэж тус тивийг ихээхэн сонирхох болжээ. Тэд Африкийн болон бусад чөлөөлөгдсөн улс түмний өмнө өөрсдийгөө шантрашгүй хувьсгалчид, империализмын эсрэг, нийгмийн дэвшлийн төлөө тэмцэгчид болгон харуулах гэж оролдож байгаа нь «марксизмын онолын ялалт нь түүний дайснуудыг марксист дүртэй болгон зүсээ хувиргахад хургэдэг»¹ гэж В. И. Лениний хийсэн дүгнэлт ямар мэргэн болохыг нотолж байна.

50-иад оны сүүлчээр Африкийн орнуудын нийгмийн бүтцэд тариачид зонхилж, энэ тивийн орнуудын эдийн засгийн хоцрогдмол байдал, нийгмийн хөгжлийн замаа хараахан сонгон авч дуусаагүй байгаа зэргээс шалтгаалж маоизмыг тус тивд нэвтрүүлэх таатай нөхцөл бүрдүүлнэ гэж Бээжингийнхэн горилж байжээ. Үүний тулд хятадын удирдлага африкийн зарим орны удирдагчдын үндсэрхэг үзлийг ашиглан «гурав дахь ертөнцийг» арьсны үзлийн үндсэн дээр нэгтгэн нягтруулахыг уриалж байлаа.

60-аад оноос БНХАУ Африкт явуулж буй үйл ажиллагаагаа мэдэгдэхүйц идэвхжүүлж иржээ. Хэрэв 1958 онд БНХАУ тус тивийн тусгаар тогтносон гуравхан оронтой дипломат харилцаатай байсан бол 1962 оны сүүлчээр арван оронтой, 1965 онд 18 оронтой дипломат харилцаа тогтоосон байна. Бээжингийнхэн тэдгээр улсуудтай техник-эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулж, эдийн засгийн хөнгөлттэй буюу буцалтгүй тусламж үзүүлэхээр амлаж байсан билээ. Гэвч тэр бүх амлалт нь бүрэн гүйцэд биелэгдээгүй юм. БНХАУ Африкийн орнуудад 430 сая долларын зээл олгохоор амласан боловч 1965 оны эцэс гэхэд түүнийхээ дөнгөж гуравны нэг хувийг олгожээ.

1963 оны эцэс, 1964 оны эхээр Жоу Энълайн Африкийн улсуудад хийсэн айлчлал нь ердийн албан ёсны айлчлал мэт боловч түүний цаана хятадын удирдагчдын хэтийн төлөвлөгөө халхлагдан нуугдаж байлаа. Энэ айлчлал нь ЗХУ-ын эсрэг илэрхий чиглэлтэй байсан бөгөөд тус тивийн тусгаар тогтносон бүх улсыг Хятадыг тойруулан нэгтгэх зорилготой байжээ. Хятадын ерөнхий сайд агсан Жоу Энълай айлчлалынхаа

¹В. И. Ленин. Зохиолын 18-р боть. 599 дэх тал.

үед БНХАУ-аас Африкийн орнуудтай харилцах «онцгой таван зарчим»*, африк-азийн орнуудтай эдийн засгийн талаар харилцах «онцгой найман зарчим»** гэгчийг тунхагласан байна.

Жоу Энълай Африкт хийсэн айлчлалынхаа үед «Африк тив африкчуудынх байх ёстой»¹ гэсэн лозунг дэвшүүлснээрээ тус тивд арьсны үзлийг дэлгэрүүлэх зорилго тавьжээ.

1960-68 онуудад Бээжингийн улс төрийн гадаад бодлого нь «Хун-вэйбиний дипломатын үе» гэж нэрлэгдэн хятадын «соёлын хувьсгалыг» экспортлох гэсэн маогийнхны эрмэлзлэлээр тодорхойлогдож байв. 1967 онд Бээжинд болсон хятадын дипломатуудын зөвлөлгөөнөөс Африкт «соёлын хувьсгалыг» бэлтгэн явуулахдаа залуучууд болон радикал бүлгүүдийн төлөөлөгчдөөс өөрийн талд тохирох этгээдүүдийг элчин сайдын яамдаар дамжуулан татаж авах, шашны байгууллагуудын өрсөлдөөнийг ашиглах, улс төрийн замбараагүй байдал бий болгох үндсэн дээр «соёлын хувьсгалыг» зохион явуулах удирдамжийг өгсөн байна. Хятадын дипломатууд «соёлын хувьсгалыг» зохион явуулахын тулд улс орнуудын дотсод хэрэгт оролцон, засгийн газарт нь шахалт үзүүлэх, маогийн үзэл санаагаар зэвсэглэсэн бүлэглэлүүдийг байгуулах зэрэг элдэв өдөөн хатгалгыг хийж байлаа. Мөн түүнчилэн хятадын удирдлага 1967 оныг «Бүх африк-азийн хувьсгалт улс түмнүүдийн агуу их ялалтын он»² болгон зарлажээ.

Энэ үед Бээжингийнхэн империализм, колоничлолтой тэмцэхийг уриалах нэрийн дор ӨАБНУ, Родезийн арьсны үзэлтнүүдтэй эдийн засгийн харилцаагаа улам өргөжүүлж байв. «Соёлын хувьсгалын» жилүүдэд африкт хэрэглэсэн тактик нь өчүүхэн ч амжилт олоогүйгээр барахгүй хятад-африкийн орнуудын харилцааны хөгжлийг удаашруулан саатуулж улмаар африкчуудын эсэргүүцэл, дургүйцэлтэй тулгарсан юм. Жишээ нь, Каирын «Африк нувель» сэтгүүлд «соёлын хувьсгалыг» Бээжингийн шинэ колоничлолын загвар³ гэж дугнэжээ.

«Соёлын хувьсгал»-ын жилүүдэд африкийн нилээд хэдэн орон БНХАУ-тай тогтоосон дипломат харилцаагаа тасалсан байна. Тухайлбал, 1965-1966 онд Бурунди, ТАБНУ, Дагомей, Гана улс БНХАУ-тай дипломат харилцаагаа тасалсан бөгөөд Тунис, Бенин, Уганда дараа нь Марокко, Судан, Сомали зэрэг бусад оронтой тогтоосон хятадын харилцаа эрс мууджээ.⁴

Ийнхүү Бээжингийн илт түрэмгий бодлого нуран унасны дараа тэд өөрсдийн тактикийг өөрчлөхөөс өөр аргагүй болжээ. 1969 оноос БНХАУ-

*Империализм, шинэ колоничлолын эсрэг үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэж буй африкийн улс түмнийг дэмжих; африкийн орнуудын засгийн газрын энх тайван, төвийг сахих ба эвсэлд үл нэгдэх бодлогыг дэмжих; африкийн ард түмний эв санааны нэгдлийн төлөө эрмэлзлэлийг дэмжих; бүх зөрчлийг энх тайвны замаар шийдвэрлэх; африкчуудын чармайлтыг дэмжих; африкийн орнуудын тусгаар тогтнолыг хүндэтгэх, тэдний догоод хэрэгт үл оролцох, «Жэньминь жибао», 1964. 1. 30.

**Эрх тэгш харилцан ашигтай ажиллах; тусгаар тогтнолыг хүндэтгэж ямар нэг давуу талтай болзол шаардахгүй байх; бага хүүтэй буюу хүүгүй зээллэгийг удаан хугацаагаар олгох; бусад орныг хараат байдалд оруулахгүй байх; богино хугацаанд бага зардлаар олон үйлдвэр байгуулахад туслах; дээд зэргийн чанар сайтай төхөөрөмжийг дэлхийн зах зээлийн үнээр нийлүүлж, хэрэв стандартад тохирохгүй бол буцаан авч сольж өгөх; тусгаар тогтносон улсуудын иргэдэд шинэ техник эзэмшүүлэх; хятад зөвлөгч ба техникийн ажилчдыг нутгийн ардын нэгэн адил амьжиргааны хэмжээгээр хангах.-«PekingReview» 1964. N 5, pp. 8—9

¹«Жэньминь жибао», 1964. II. 18.

²«East African Standart», March, 14., 1967,

³«Afrique nouvelle», 1967, N 1039, p. 10.

⁴«Жэньминь жибао», 1965. XI. 20

ын дипломат үйл ажиллагаа дахин идэвхжиж ирлээ. Бээжингийн гадаад бодлогын шинэ үе ХКН-ын IX их хурлын дараа эхэлсэн юм. 1969-1970 онуудад Африкт БНХАУ-ын Элчин Сайдын Яамдын ажил дахин сэргэж, Африкийн улсуудад тохируулан «уян хатан» бодлого явуулж, үйл ажиллагаагаа цөөн тооны хэдэн оронд тухайлбал Заир, Танзани, Замби зэрэг орнуудад төвлөрүүлж эхэлжээ. 1970 он гэхэд Этиоп, Эквадорын Гвинейтэй дипломат харилцаа тогтоож, Кенитэй харилцаагаа дахин сэргээсэн байна.¹

Тэр үед НҮБ-ын гишүүн орнуудын гурваны нэг хувийг африкийн улсууд эзэлж байсан учир тэдний дэмжлэгийг ашиглан НҮБ-д орох, Тайванийг тус байгууллагаас гаргах явдалд үлэмж тус болно гэдэгт итгэж, африкийн орнуудтай тасарсан харилцаагаа сэргээж ирэв.

БНХАУ-ыг 1971 онд НҮБ-д суудлаа эзэлсний дараа Хятадын эрх баригчид Хятад улс «гурав дахь ертөнц»-д хамаарагдах юм гэж илэрхий зарласан билээ. Ийнхүү БНХАУ-ыг социалист орнуудын хүрээнээс гаргаж «гурав дахь ертөнцийн» хүрээнд оруулсан нь дэлхийд жанжлан ноёрхох тэмцэлдээ «гурав дахь ертөнцийн» орнуудыг өөртөө татаж, улмаар ЗХУ, социалист нөхөрлөлийн орнуудын эсрэг явуулж буй тэмцлийнхээ стратеги талбар болгон ашиглах зорилготой юм.

70-аад оны үеэр хятадын удирдлага «бага, дунд» орнуудыг «хоёр хэт их гүрэн» тухайлбал ЗСБНХУ, АНУ-ын эсрэг сөргүүлэн тавих бодлого явуулж байсан бол одоо өрнөдийн гүрнүүд болон АНУ-тай улам ойртож, «бага, дунд» орнуудыг өөрөөр хэлбэл хөгжиж байгаа орнуудыг социалист хамтын нөхөрлөлийн орнуудын эсрэг ялангуяа ЗХУ-ын эсрэг хандуулах бодлого явуулж байгаа нь хятадын одоогийн маоист эрх баригчдын гадаад улс төрийн бодлогын гол зорилго болж байгаа бөгөөд тэд үүнийгээ ч Хягадад явуулж байгаа нийгэм-эдийн засгийн амьдралыг «зохицуулах» дотоод бодлоготойгоо нягт уялдуулж байгаа юм.

Хятадын эрх баригчдын явуулж буй бодлого бол хамгийн харгис хүчинтэй эвсэхэд чиглэж, империализмын эрх ашигт улаан цайм үйлчилж байгааг Анголд болсон хэрэг явдалтай уялдуулж үзэхэд тодорхой харагдаж байна.

Африк тивийн бүрэн эрхт хамгийн шинэ тулгар улсын дайснууд эрх чөлөөнийхөө төлөө тэр ард түмний хийсэн арван таван жилийн зэвсэгт тэмцлийг арчин хаях, Анголын ард түмний манлай-Анголыг чөлөөлөхийн төлөө ардын хөдөлгөөн (МПЛА)-ийг улс орны удирдлагаас зайлуулах, удирдагчдыг нь алж хядан, Анголыг чөлөөлөх үндэсний фронт (ФНЛА), Анголын төгс тусгаар тогтнолын төлөө үндэсний холбоо (УНИТА) гэгч империализмын гар хөл бологч тоглоомын дэглэмийнхнийг Анголд тулган хүлээлгэх гэж оролдсон нь Анголд болсон хэрэг явдлын талаархи бээжингийн бодлогын мөн чанарыг улам тод харуулав.

Анголын нутаг дахь тулалдааны явцад африкчууд олон улсын тайзан дээр хэн жинхэнэ нөхөр, хэн заналт дайсан гэдгийг нэн тод харсан билээ. ЗХУ, Куба болон бусад социалист орнууд анголын баатарлаг ард түмэнтэй эв санаагаа нэгтгэн, тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө тэмцэлд нь тусалсан юм. Гэтэл Хятадын эрх баригчид империалист гүрнүүдтэй эвсэн ЗХУ болон Кубын ард түмнээс үзүүлсэн интернационалч тусламжийг ичгүүр сонжуургүй гүтгэн гуйвуулж, дайран давшилсан юм.

Бээжингийн удирдагчид Анголын ард түмний эсрэг хорлон сүйтгэх ажиллагаагаа арван таван жилийн турш зогсоогоогүй бөгөөд анголын ард түмний жинхэнэ төлөөлөгчид, түүний манлай МПЛА-гийн эсрэг харгис хүчнийг түлхэн, харгис хүчний талд орж, Анголын ард түмний дотоод

¹ «Жэньминь жибао», 1970. X .20

хэрэгт оролцохоор эрмэлзэж ирснийг Бээжингийн хандлага нэгэнт гэрчилсэн билээ.

Алжирийн «Революсьон африкэн» сонинд: «...анголын ард түмний эсрэг ФНЛА, УНИТА-гийн хөдөлгөөн нь Африк, өрнөдийн хамгийн харгис хүчин, тэрчилэн «жанжлахыг эсэргүүцэгч хүч» гэж өөрийгөө тооцдог цөмийн гүрний нэг болох Хятадын тусламж дэмжлэгэнд тулгуурлаж байна»¹ гэжээ.

Заирт өрнөдийнхний үйлдсэн зэвсэгт халдлага нь Африкт шинэ колоницлолын дэглэмийг хэвээр хадгалж, африкийн улсуудыг дэвшилт замаар хөгжихөд нь саад хийх гэсэн империалистуудын стратегийн бодлого байсан бөгөөд түүнийг бээжингийн эрх баригчид дэмжин, өрнөдийнхөнтэй холбоо бүхий дотоодын харгис дэглэмийнхэнд зэр зэвсэг хүртэл нийлүүлж байсан юм. БНХАУ-ын Гадаад явдлын Яамны сайд Хуан Хуа 1978 оны зургадугаар сард Заирт очиж НАТО-гийн түрэмгийлэгчдийн балмад үйл ажиллагааг сайшааж, Заирт зэвсэг өгөхөөр амласан байлаа.

Нигерийн тусгаар тогтнолын төлөө тэмцлийн үеэр маогийнхан салан тусгаарлагчдын «Биафрын улс» гэгчийг байгуулахын төлөө тэмцэл, хагалан бутаргагч хүчийг дэмжсэн юм. БНХАУ-ын төлөөлөгчид Руаида, Бурундын бхуту, ватут омгийн хоорондын зөрөлдөөнийг хурцатгах, Сомали, Этиопийн хооронд нутаг дэвсгэрийн мөргөлдөөн үүсгэх, Өмнөд Суданы хагалан бутаргагчдын хөдөлгөөнийг сэргээхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн билээ. Африкийн улсуудын хооронд гарч буй дээрх мөргөлдөөн нь хятадын жанжлалыг дэлгэрүүлэх зорилгоор дэлхийн янз бүрийн районд түгшүүртэй байдлын голомт бий болгох гэсэн Бээжингийн эрх баригчдын бодлогод нийцэж байгаа юм.

Тэгээд ч Бээжингийнхэн Африкийн Эвэрийн районыг нилээд эрт үеэс сонирхох болсон байна. Энэ район нь тэнгисийн чухал зам харилцааны уулзварт нефть олборлодог гол гол орнуудтай зэргэлдээ оршдоггоороо бээжингийнхний сонирхлыг татах болсон юм. 50-иад оны үеэс Бээжингийнхэн Энэтхэгийн далайн баруун эргийг хяналтдаа авахыг санаархсан юм. Тийнхүү «Аугаа их Сомалийн холбоо» гэгчийг Хятад дэмжиж 1963 онд Сомали, Этиопийн харилцаа үлэмж хурцдахад хятадын удирдагчид Сомалид тал засч 20 сая гаруй долларын хүүгүй зээллэгэ олгохоор амласан бол 1978 онд Сомалийн армийг хятадын зэвсгээр хангажээ.

Намибид Бээжингийнхэн Баруун Өмнөд Африкийн Ардын байгууллагыг (СВАПО) дэмжихээс татгалзаж, дотоодын харгис хүчин болох Баруун өмнөд Африкийн Үндэсний Холбоо (СВАНУ)-г дэмжин тэтгэж байлаа. Хожим нь хятадын удирдлага арга буюу СВАПО-г хүлээн зөвшөөрсөн хэдий боловч намибийн эрх чөлөөний хөдөлгөөний дотор хорлон сүйтгэх үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байна.

ӨАБНУ-д империалист бүлгийнхэнтэй холбоо бүхий үндэсний цөөн урвагчдыг хятадын удирдлага онцлон үзэж байлаа. Тэд нармай африкийн конгрессийн коммунизмын эсрэг үзэлтэн, урвагч нарт улс төр, санхүүгийн «өгөөмөр тусламж» үзүүлсээр байна. БНХАУ, ӨАБНУ-ын хоорондох эдийн засаг, худалдааны хэлхээ холбоо сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжсөөр байна. БНХАУ-аас ӨАБНУ-д «шууд бусаар» гаргасан барааны өртөг 1978 онд 6 сая доллар болсон ба сүүлийн үед арьсны үзэлтнүүдийн арми болон цагдаагийн формын хувцасны бөс бараа, хятадад үйлдвэрлэсэн шоронгийн цоож, түгжээ, гав гинж, эрүү шүүлтийн хэрэгслийг гаргах болсон нь бүр ч ичгүүр сонжуураа алдсан хэрэг мөн.

¹«La Revolution Africain», 1975. XII. 6

Хятадын удирдагчид Өмнөд Африкийн ард түмний тэмцлийг дэмжинэ гэж аман дээрээ мэдэгддэг боловч үнэн хэрэгтээ ийнхүү империалистууд, арьсны үзэлтний талд зогсож, тэдний шинэ колоничлолын бодлогыг идэвхтэй дэмжигч нь болж байка.

Бээжингийн удирдагчид 60-аад оны үед Африкт үзэл суртлын талаар дарамт шахалт үзүүлэх, хорлон сүйтгэх явууллага хийхэд гол анхаарлаа хандуулж байсан бол 70-аад оны үеэс эхлэн африкийн орнуудад эдийн засгийн талаар нөлөөлөх явдлыг онцгой ач холбогдолтойд үздэг болжээ. Гэвч Хятадын эдийн засгийн тусламж нь мөн л гуйлиа цухуйлгасан юм. Ганцхан жишээ дурдахад 1976 оны дундуур ашиглалтанд оруулсан нэртэй Танзани, Замбид тавьсан «Танзам» төмөр зам (1800 км урт) тэр цагаас байнга осол эвдрэл гарсаар тээвэр тасалдаж Бээжингийн «тусламжийн» хамгийн том барилга байгууламж гэж сүр бадруулсан уг төмөр замыг дахин засварлах явдал нь тус орны эдийн засагт үлэмж хохирол учруулсаар байна.

БНХАУ африкийн орнуудад 300 гаруй нэр төрлийн үйлдвэр барьж байгуулахаар амласан хэдий боловч одоогийн байдлаас үзэхэд дөнгөж 166-г барьж ашиглалтад оруулсан бөгөөд тэдгээрийн ихэнх нь «Танзам»-ын нэгэн адил хоцрогдсон техникээр тоноглогдсон буюу зарим үйлдвэрийн бүтээгдэхүүн тэдгээр улсуудын эдийн засагт ямар ч үр ашиггүй, чанар муугаас болж харин ч саад учруулсаар байна. Хятад улс мал аж ахуй байхгүй Занзибарт арьс шир, гутлын үйлдвэр, тамхины тариалан ч байхгүй, цаасны үйлдвэр ч үгүй Мали, Гвинейд янжуурын фабрик барьж өгсөн нь хятадын эрх баригчид уг орнуудын эрх ашгийг бодохоосоо илүү өөрийн улс төрийн болон худалдаа наймааны ашиг хонжоог илэрхий бодсон нь бүрэн нотлогдож байгаа юм.

Эдийн засагчдын тооцоолсноор бол Бээжин чөлөөлөгдсөн орнуудтай хийсэн тэнцвэргүй худалдаанаасаа сүүлийн таван жилд 4 тэр бум гаруй долларын ашиг хонжоо олжээ.

БНХАУ-аас Африкт явуулж буй улс төр, эдийн засгийн үйл ажиллагаа нь хятадын эрх баригчдаас нилээд олон жилийн өмнө тунхагласан хятад-африкийн харилцааны «Онцгой таван зарчим», эдийн засгийн харилцааны «онцгой найман зарчим»-тай огт авцалдахгүй болж, Бээжингийн эрх баригчид социализм, олон улсын ажилчин анги, үндэсний эрх чөлөөний эрх ашгаас урваж, империалист харгис хүчин, арьсны үзэлтнүүдтэй нэгэн эгнээнд зогсож байгаа нь бүр ч тодорхой болсоор байна.

Африкт түгшүүртэй байдлыг дэвэргэх, зэвсэгт мөргөлдөөн дэгдээхэд чиглэсэн хятадын удирдагчдын чиг шугам нь империализм, арьсны үзэлтнүүдийн үйл ажиллагаатай улам бүр хосолж, Африкт хувьсгалт хүчнийг сулруулахад чиглэснээрээ тус тивийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг нухчин дарах гэж оролдож байгаагийн нотолгоо болж байна. Маогийнхны баримталж буй энэ бодлого дэлхийн дэвшилт олон нийтийн жигшил зэвүүцлийг төрүүлж байгаа нь зүйн хэрэг юм.

Африкийн орнуудын дунд социалист орнууд, ялангуяа ЗХУ-ын нэр хүндийг гутаах гэсэн Бээжингийнхний, оролдлого сүүлийн үед улам хэнээрхлийн шинжтэй болж байна. Хятадын удирдагчид зөвлөлтийн эсрэг үзлээ хэрэгжүүлэхийн тулд Зөвлөлт улс Африкт «түрэмгийлж» тус тивийг бүхэлд нь «залгих»-ыг санаархаж байгаа мэтээр гүтгэж байгаа нь Африкийн орнуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс улам их оролцоход АНУ болон өрнөдийн гүрнүүдийг турхирах зорилготой юм.

¹Гегемонистская политика Китая-угроза народам Азии, Африки и Латинской Америки. М., 1981., с. 248.

Гэвч шинэ колоничлол, арьсны үзэлт дэглэм, маоизмын эсрэг африкийн улс түмний тэмцэл улам өргөжин бэхжиж байна. Африкийн шинэ тулгар хөгжиж байгаа орнуудын ард түмэн хятадын удирдагчдын эзлэн тэлэх, жанжлах бодлогыг хүлээж аваагүй ба авах ч үгүй бөгөөд харин ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай улс төр, эдийн засаг, техникийн болон худалдаа, соёлын хамтын ажиллагаагаа улам ч өргөжүүлэн хөгжүүлсээр байна.

ПОЛИТИКА ПЕКИНА В АФРИКЕ

(Резюме)

3. Эрдэнэчимэг

Большое место в глобальной стратегии нынешнего пекинского руководства занимает африканский континент.

В 60-е годы начинается заметная активизация китайской политики в Африке. Если в 1958 году КНР имела дипломатические отношения только с тремя странами, то в 1965 году дипломатические отношения были установлены с 18 африканскими странами. Политика Пекина в Африке в этот период была названа «дипломатией хунвэйбинов» и определялась попытками маоистского руководства «экспортировать» культурную революцию на африканский континент. Однако эта политика грубого вмешательства во внутренние дела африканских стран потерпела провал и привела к разрыву дипломатических отношений некоторыми африканскими государствами с КНР.

С начала 70-х годов Пекин меняет свою политическую тактику. Начиная с 1971 года, когда представитель КНР занял свое место в ООН, Китай, объявив о своей принадлежности к «третьему миру», начинает проводить политику, направленную на привлечение внимания стран «третьего мира» к себе что явилось составной частью общей антисоциалистической стратегии пекинского руководства во внешней политике.

В 70-е годы Китай придает особое значение расширению экономического влияния на африканские государства. Обещая построить и полностью оборудовать более чем 300 заводов и промышленных объектов для африканских стран, КНР с трудом выполнила обещание только наполовину. Кроме того, промышленные объекты были оборудованы устаревшей технологией и построены без учета экономических потребностей этих стран, что оказало негативное влияние на экономику этих государств.

Проводимая Пекином линия на нагнетание напряженности на африканском континенте, грубое вмешательство во внутренние дела независимых африканских государств и провоцирование вооруженных конфликтов отчетливо показывают, что нынешнее китайское руководство стоит в одном ряду с реакционными и империалистическими, рассистскими силами, злейшими противниками свободы и независимости народов мира.